

ХҮН АМЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Хүн амын хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний мэдээ, тайлан гаргах, судалгаа явуулах зорилгоор “Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал”-ыг Үндэсний статистикийн хорооны дарга, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын хамтарсан тушаалаар 2009 онд шинэчлэн баталснаар хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний статистикийн үзүүлэлтийг “Ажиллах хүчний судалгаа”-ны үр дүнгээс тооцож байна. Хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтүүдийг 2009 он хүртэл аймаг, нийслэлийн засаг захиргааны анхан шатны нэгжээс мэдээлдэг “Хүн амын ажил эрхлэлтийн жилийн тайлан”-гийн дүнгээр гаргаж байсан.

Монгол улсад “Ажиллах хүчний судалгаа”-г 2002-2003 онд анх удаа олон улсын нийтлэг аргачлалын дагуу улирлаар явуулсан нь хөдөлмөрийн зах зээл дэх улирлын хэлбэлзлийг тусгасан хүн амын хөдөлмөр эрхлэлтийн үндэсний хэмжээний суурь судалгаа болсон. Харин “Статистикийн тухай” Монгол улсын хуулинд 2004 онд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр 2006 оноос эхлэн “Ажиллах хүчний судалгаа”-г улирлаар явуулж, үр дүнг нэгтгэн тархаадаг болсон.

Ажиллах хүчний судалгаанд нийслэлийн 9 дүүргээс түүврээр сонгогдсон өрхөөс мэдээллийг сар бүр цуглуулж, улирлаар нэгтгэж, үр дүнг гаргадаг.

Шинэчлэн батлагдсан аргачлалын дагуу ажиллах хүчний судалгааны дүнгээр тооцож гаргаснаар 2015 онд улсын хэмжээнд эдийн засгийн идэвхтэй хүн ам 1243.9 мянга байгаагийн 39.7 хувь, хөдөлмөр эрхэлж буй 1151.2 мянган ажиллагчид байгаагийн 40.0 хувь нь тус тус нийслэл Улаанбаатар хотод амьдарч байна. Эдийн засгийн идэвхтэй хүн ам (ажиллах хүч)-д тухайн цаг хугацаанд бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд ажиллах хүчээ нийлүүлж байгаа ажиллагч, нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүй иргэдийг хамруулна. Эдийн засгийн идэвхтэй хүн амыг эдийн засгийн байнгын идэвхтэй хүн ам, эдийн засгийн тухайн үеийн идэвхтэй хүн ам гэж хоёр ангилах бөгөөд энд танилцуулж буй мэдээллийг эдийн засгийн тухайн үеийн идэвхтэй хүн амаар гаргасан болно.

Хүснэгт 1. Нийслэлийн хүн амын хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлт, 2010-2015 он

Үзүүлэлт	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он
15 ба түүнээс дээш насны хүн амын тоо	748,418	710,259	735,759	845,487	870,776	917,814
Эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо	395,149	382,810	393,321	447,293	476,138	494,106
Үүнээс:						
Ажиллагчдын тоо	360,884	361,404	365,287	426,731	451,819	459,971
Ажилгүй иргэдийн тоо	34,265	21,406	28,034	20,562	24,319	34,135
Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо	9,088	29,331	12,811	14,143	15,787	12,640
Эдийн засгийн идэвхгүй хүн амын тоо	353,269	327,449	342,438	398,194	394,638	423,708
Ажиллах хүчний оролцооны түвшин	52.8	53.9	53.5	52.9	54.7	53.8
Хөдөлмөр эрхлэлтийн түвшин	48.2	50.9	49.6	50.5	51.9	50.1
Ажилгүйдлийн түвшин	8.7	5.6	7.1	4.6	5.1	6.9

Зураг 1. Хүн амын хөдөлмөр эрхлэлт



Эдийн засгийн идэвхтэй хүн амын тоог хөдөлмөрийн насны хүн амын тоонд харьцуулсан дүнгээр илэрхийлэгддэг ажиллах хүчний оролцооны түвшин 53.8 хувьтай байна.

Ажиллах хүчний судалгааны тооцоогоор 2015 онд эдийн засгийн идэвхтэй хүн ам 494.1 мянга байгаагаас 460.0 мянга буюу 93.1 хувь нь ажиллагчид, 34.1 мянга буюу 6.9 хувь нь ажилгүй иргэд байна.

Эдийн засгийн үйл ажиллагааны бүх төрлийн

салбарт ажиллагсдын тоо 2010 онд 360.9 мянга, 2011 онд 361.4 мянга, 2012 онд 365.3 мянга, 2013 онд 426.7 мянга, 2014 онд 451.8 мянга, 2015 онд 460.0 мянга болжээ. Ажиллагч гэж цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож, хөдөлмөр эрхлэлтийн аль нэг хэв шинж (статус)-д хамрагдаж буй иргэнийг ойлгоно. Цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд сүүлийн 7 хоногт нэгээс дээш цагаар оролцсон бол ажиллагч гэж үзсэн.

Хүснэгт 2. Ажиллагчдын тоо, дүүргээр, 2010-2015 он

Дүүрэг	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он
Ажиллагчид, бүгд	360,884	361,404	365,287	426,731	451,819	459,971
Багануур, Багахангай	7,941	8,975	10,691	9,627	10,034	10,303
Баянгол	50,290	57,937	60,585	76,371	76,121	71,626
Баянзүрх	91,734	86,492	87,698	107,637	103,001	109,583
Налайх	10,214	9,616	9,074	10,782	11,831	14,614
Сонгинохайрхан	77,625	79,548	71,335	87,092	103,318	107,105
Сүхбаатар	46,468	46,273	44,925	45,120	47,247	46,778
Хан-Уул	35,071	37,393	33,478	43,076	52,088	53,318
Чингэлтэй	41,541	35,170	47,501	47,026	48,179	46,644

Багахангай дүүргийн хувьд хүн амын тоо цөөн учир судалгааны түүвэрлэлт хийхдээ Багануур дүүрэгтэй нэгтгэн түүврийн нэгж болгосон тул үр дүнг тооцож гаргахад Багануур, Багахангай дүүргийн хүн амын хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлт нэгдсэн байдлаар гарсан болно.

Ажиллах хүчний судалгааны дүнгээр ажилгүй иргэдийн тоог эдийн засгийн идэвхтэй хүн амын тоонд харьцуулан тооцсон ажилгүйдлийн түвшин 6.9 хувь болж өмнөх оноос 1.8 пунктээр өссөн


байна. Ажилгүй иргэн гэж тухайн хугацаанд ажилгүй байсан, ажил хийхэд бэлэн, ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай иргэнийг хэлнэ.

Хүснэгт 3. Ажилгүй иргэдийн тоо, дүүргээр, 2010-2015 он

Дүүрэг	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он
Ажилгүй иргэд, бүгд	34,265	21,406	28,034	20,562	24,319	34,135
Багануур, Багахангай	2,683	2,831	744	1,717	1,272	516
Баянгол	7,099	5,603	4,188	5,230	5,273	6,161
Баянзүрх	5,967	3,402	6,660	2,792	2,499	6,983
Налайх	1,565	882	887	154	114	2,309
Сонгинохайрхан	7,178	1,999	3,901	3,739	4,782	6,840
Сүхбаатар	2,782	1,710	3,216	1,333	3,604	2,084
Хан-Уул	404	1,875	3,170	1,397	3,070	3,680
Чингэлтэй	6,587	3,104	5,268	4,200	3,705	5,562

2015 оны байдлаар ажиллах хүчний судалгааны дүнгээр тооцсон ажилгүйдлийн түвшин Говьсүмбэр аймагт хамгийн өндөр буюу 16.5 хувь, Орхон аймагт хамгийн бага буюу 2.2 хувь байгаа бол нийслэл Улаанбаатар хотод 6.9 хувьтай байгаа нь улсын дунджаас 0.6 пунктээр доогуур байна.

Зураг 2. Ажилгүйдлийн түвшин, ажиллах хүчний судалгааны дүнгээр, 2015 он



Нийт ажиллагчдын 21.5 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний, 13.2 хувь нь барилгын, 10.5 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн, 9.2 хувь нь тээвэр ба агуулахын үйл ажиллагаа, 7.3 хувь нь боловсролын салбарын аж ахуйн нэгж, байгууллагуудад ажиллаж байна.

Хүснэгт 4. Ажиллагчдын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он
Ажиллагчид, бүгд	360,884	361,404	365,287	426,731	451,819	459,971
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	8,595	8,679	10,872	9,181	9,348	7,995
Уул уурхай, олборлолт	11,593	15,299	19,364	23,570	18,673	18,236
Боловсруулах үйлдвэрлэл	34,670	34,419	34,785	47,416	52,754	48,114
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	5,622	5,009	7,077	5,467	7,085	7,191
Усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	3,571	2,749	2,892	3,777	4,483	3,542
Барилга	33,826	34,252	37,571	48,396	57,825	60,682
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	80,623	82,510	72,893	89,275	95,526	99,031
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	43,867	43,751	30,816	36,929	39,233	42,213
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	16,263	16,498	18,872	17,807	22,927	22,390
Мэдээлэл, холбоо	9,488	8,306	10,556	12,815	13,803	12,205
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	8,456	9,215	9,649	12,456	14,305	13,263
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	418	205	905	616	885	733
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	5,917	6,333	5,998	8,164	7,566	8,581
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	7,006	7,380	9,896	11,401	9,048	12,952
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	23,709	20,298	26,388	27,208	30,049	31,024
Боловсрол	33,048	32,680	32,441	33,308	33,740	33,718
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	17,861	16,276	16,339	18,652	17,872	18,327
Урлаг, үзвэр, тоглоом наадам	5,091	4,027	3,203	5,032	4,610	7,281
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	9,907	11,583	11,418	13,009	10,535	10,951
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	128	325	526	635	355	430
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	1,225	1,610	2,826	1,617	1,197	1,112

2015 онд хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур, үүл үурхай, олборлолт, боловсруулах үйлдвэрлэл, усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа, зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ, мэдээлэл холбоо, санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа, боловсрол, олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагааны салбарт ажиллагсдын тоо 2014 оноос бүүрч, харин бусад салбарт ажиллагчдын тоо өсчээ. Эдийн засгийн үйл ажиллагааны салбараар улсын дүнд хамгийн бага буюу 2.4 хувийг хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбарт, хамгийн их буюу 81.0 хувийг удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбарт ажиллагчид эзэлж байна.

Хүснэгт 5. Ажиллагчдын тоо, аж ахуйн нэгж байгууллагын хариуцлагын хэлбэрээр

Хариуцлагын хэлбэр	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он
Ажиллагчид, бүгд	360,884	361,404	365,287	426,731	451,819	459,971
Компани	136,497	147,653	166,335	200,134	220,485	226,323
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	121,048	119,094	95,394	124,564	119,362	118,176
Төсөвт байгууллага	79,564	74,949	72,028	77,676	81,743	84,216
Улсын үйлдвэрийн газар	14,655	11,252	19,970	17,101	19,390	21,066
Нөхөрлөл	1,584	1,132	832	138	363	1,140
Хоршоо	517	366	954	798	1,701	1,449
Төрийн бус байгууллага	7,019	6,958	9,774	6,320	8,775	7,601

2015 оны байдлаар нийслэл хотод ажиллагчдыг ажиллаж буй аж ахуйн нэгж, байгууллагын хариуцлагын хэлбэрээр нь ангилбал 49.2 хувь буюу 226,323 нь хязгаарлагдмал хариуцлагатай болон хувьцаат компани, 25.7 хувь буюу 118,176 нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 18.3 хувь буюу 84,216 нь төрийн төсөвт, 4.6 хувь буюу 21,066 нь төрийн өмчит болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, 0.2 хувь буюу 1,140 нь нөхөрлөл, 0.3 хувь буюу 1,449 нь хоршоо, 1.7 хувь буюу 7,601 нь төрийн бус байгууллагад тус тус ажиллаж байна.

Хүснэгт 6. Ажиллагчдын тоо, хөдөлмөр эрхлэлтийн статусаар

Хөдөлмөр эрхлэлтийн статус	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он
Ажиллагчид, бүгд	360,884	361,404	365,287	426,731	451,819	459,971
Цалин хөлстэй ажиллагч	227,270	231,169	265,045	295,211	312,161	321,407
Ажил олгогч	7,922	9,454	4,990	8,281	10,691	8,342
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	115,542	107,145	80,368	107,475	111,269	116,248
Мал аж ахуй эрхлэгч	4,140	5,754	5,213	4,923	6,164	4,694
Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч	5,393	7,591	8,987	10,715	11,008	9,158
Эдгээр статуст хамрагдах боломжгүй ажиллагч	617	291	684	126	526	122

2015 оны байдлаар ажиллагчдыг хөдөлмөр эрхлэлтийн статусаар нь ангилбал 69.9 хувь буюу 321,407 нь цалин хөлстэй ажиллагч, 1.8 хувь буюу 8,342 нь ажил олгогч, 25.3 хувь буюу 116,248 нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 1.0 хувь буюу 4,694 нь мал аж ахуй эрхлэгч, 2.0 хувь буюу 9,158 нь өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч байна.

Хүснэгт 7. Ажиллагчдын тоо, насны бүлгээр

Насны бүлэг	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он
Ажиллагчид, бүгд	360,884	361,404	365,287	426,731	451,819	459,971
15 - 19	3,273	4,574	5,358	3,604	4,664	4,497
20 - 24	34,599	38,170	35,937	44,225	43,964	41,718
25 - 29	57,984	56,197	63,763	72,058	75,178	71,374
30 - 34	57,374	56,065	57,426	65,987	67,981	73,906
35 - 39	62,154	61,925	60,244	64,245	81,020	78,806
40 - 44	53,524	50,394	49,566	63,267	62,684	65,961
45 - 49	46,140	49,205	44,813	54,842	53,957	58,064
50 - 54	30,122	28,859	31,222	38,392	41,488	42,530
55 - 59	10,626	10,844	11,955	16,843	14,749	18,001
60 - 64	3,143	2,938	2,650	2,824	3,825	3,498
65 - 69	1,326	962	1,351	387	1,114	1,092
70 +	619	1,271	1,002	57	1,195	524

2015 оны байдлаар ажиллагчдыг насны бүлгээр нь ангилбал 10.0 хувь буюу 46,215 нь 15-24 насны, 31.6 хувь буюу 145,280 нь 25-34 насны, 31.5 хувь буюу 144,767 нь 35-44 насны, 21.9 хувь буюу 100,594 нь 45-54 насны, 5.0 хувь буюу 23,115 нь 55-аас дээш насны хүмүүс байна.

Хүснэгт 8. Ажиллагчдын тоо, боловсролын төвшнөөр

Боловсролын төвшин	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он
Ажиллагчид, бүгд	360,884	361,404	365,287	426,731	451,819	459,971
Боловсролгүй	1,744	1,103	1,672	929	1,102	375
Бага	3,996	3,647	3,521	2,249	2,384	3,548
Суурь	37,941	27,031	21,566	21,491	14,527	16,390
Бүрэн дунд	127,106	135,329	115,478	96,598	54,709	58,157
Техникийн болон мэргэжлийн	28,699	24,468	31,404	81,344	143,832	144,350
Тусгай мэргэжлийн дунд	36,627	17,644	25,382	28,318	36,925	28,613
Дипломын дээд болон бакалавр	118,515	145,306	148,271	182,027	184,139	194,033
Магистр ба түүнээс дээш	6,256	6,876	17,993	13,775	14,202	14,505

2015 оны байдлаар нийслэл хотод эдийн засгийн идэвхгүй хүн амын тоо 423.7 мянга болжээ. Эдийн засгийн идэвхгүй хүн амд хөдөлмөрийн нөхцөл, онцлогоос шалтгаалан тэтгэврийн наснаас өмнө тэтгэвэр, тэтгэмж тогтоолгосон хүн ам, хөдөлмөрийн чадвараа б сараас дээш хугацаагаар түр болон бүрэн алдсан иргэн, хөдөлмөрийн насны өдрөөр суралцагч, хүндэтгэх ба хүндэтгэх бус шалтгаанаар хөдөлмөр эрхлээгүй болон хөдөлмөрийн насанд хүрээгүй хүн амыг хамруулсан.

Хүснэгт 9. Эдийн засгийн идэвхгүй хүн амын тоо, дүүргээр, 2010-2015 он

Дүүрэг	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он
Эдийн засгийн идэвхгүй хүн ам, бүгд	353,269	327,449	342,438	398,194	394,638	423,708
Багануур, Багахангай	10,849	9,673	11,300	11,038	12,447	12,715
Баянгол	51,241	49,650	52,527	61,872	56,158	61,283
Баянзүрх	73,649	70,638	74,897	95,980	96,472	97,062
Налайх	10,212	12,977	10,219	12,646	11,422	9,256
Сонгинохайрхан	82,890	75,771	72,245	85,861	93,226	100,717
Сүхбаатар	37,567	41,198	43,430	43,123	40,303	44,303
Хан-Уул	40,927	31,462	33,767	42,862	38,187	45,918
Чингэлтэй	45,934	36,080	44,053	44,812	46,423	52,454

Эдийн засгийн идэвхгүй хүн амаас суралцдаг, сурахаар явах гэж байгаа, тэтгэврийн, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй, хөдөлмөрийн нас хүрээгүй иргэдийг хасвал 132.4 мянган иргэн ямар нэг шалтгаанаар хөдөлмөр эрхлээгүй байна.

Хүснэгт 10. Эдийн засгийн идэвхгүй хүн амын тоо, шалтгаанаар, 2010-2015 он

Шалтгаан	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он
Эдийн засгийн идэвхгүй хүн ам, бүгд	353,269	327,449	342,438	398,194	394,638	423,708
Гэрийн ажилтай	27,535	28,417	34,640	32,640	32,977	30,523
Суралцдаг	137,424	122,061	112,807	130,050	130,353	132,504
Сурахаар явах гэж байгаа	-	1,945	1,658	1,630	2,372	2,759
Тэтгэвэрт	76,441	69,098	74,865	88,665	111,970	122,151
Өндөр настан	2,717	7,747	15,902	19,220	2,561	3,155
Хөгжлийн бэрхшээлтэй	22,332	20,567	22,577	26,155	28,442	30,632
Ажил хийхийг хүсээгүй	5,460	5,417	5,674	8,060	7,015	6,493
Хүүхэд асарсан	43,789	39,163	34,440	52,894	49,325	61,614
Өвчтэй байсан	6,178	7,168	8,269	8,542	7,199	6,640
Хөдөлмөрийн нас хүрээгүй	-	47	122	136	-	153
Өвчтөн, өндөр настан асарсан	2,818	3,800	4101	4,409	4,186	5,643
Бусад	28,575	22,019	27,383	25,793	18,238	21,441

Хөдөлмөрийн эрхлээгүй дээрх 132.4 мянган иргэний 23.1 хувь гэрийн ажилтай, 4.9 хувь нь ажил хийхийг хүсээгүй, 46.5 хувь нь хүүхэд асардаг, 5.0 хувь нь өөрөө өвчтэй байсан, 4.3 хувь нь өвчтөн, өндөр настан асардаг, 16.2 хувь нь бусад шалтгааны улмаас хөдөлмөр эрхлээгүй байна.

Хүснэгт 11. Эдийн засгийн идэвхгүй хүн амын тоо, насны бүлгээр, 2010-2015 он

Насны бүлэг	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он
Эдийн засгийн идэвхгүй хүн ам, бүгд	353,269	327,449	342,438	398,194	394,638	423,708
15 - 19	91,964	79,495	75,717	87,234	89,789	91,796
20 - 24	70,643	64,175	61,518	68,151	60,964	59,031
25 - 29	28,969	26,593	27,571	32,323	29,823	36,950
30 - 34	21,564	20,480	20,963	25,020	21,146	26,248
35 - 39	17,498	16,580	17,722	21,487	21,080	23,681
40 - 44	13,483	13,120	13,118	16,868	16,300	18,471
45 - 49	14,732	14,221	14,986	15,768	17,530	16,857
50 - 54	17,581	18,066	19,530	20,328	25,200	25,062
55 - 59	16,728	19,134	22,211	28,926	31,992	37,729
60 - 64	18,267	17,265	23,282	25,201	27,919	30,434
65 - 69	16,549	14,395	16,931	19,196	19,245	22,441
70 +	25,291	23,925	28,889	37,692	33,650	35,008

Хүснэгт 12. Эдийн засгийн идэвхгүй хүн амын тоо, шалтгаан, дүүргээр, 2015 он

Шалтгаан	Багануур, Багахангай	Баянгол	Баянзүрх	Налайх	Сонгинохайрхан	Сүхбаатар	Хан-Уул	Чингэлтэй	Нийслэлийн ДУН
Эдийн засгийн идэвхгүй хүн ам, бүгд /мян.хүн/	12.7	61.3	97.1	9.3	100.7	44.3	45.9	52.4	423.7
Гэрийн ажилтай	1.7	3.5	11.0	0.1	6.9	1.5	2.0	3.9	30.6
Суралцдаг	4.1	22.8	30.1	3.4	31.6	12.3	13.7	14.5	132.5
Сурахаар явах гэж байгаа	-	0.7	0.8	0.1	0.7	-	0.2	0.2	2.7
Тэтгэвэрт	2.7	16.1	28.8	2.8	25.8	14.9	14.8	16.2	122.1
Өндөр настан	0.1	0.2	0.6	0.1	0.4	0.6	0.2	0.9	3.1
Хөгжлийн бэрхшээлтэй	1.3	4.6	5.6	1.6	6.7	2.8	3.6	4.4	30.6
Ажил хийхийг хүсээгүй	-	0.6	1.1	-	2.0	1.1	0.5	1.1	6.4
Хүүхэд асарсан	1.5	7.8	14.1	0.9	16.6	7.3	6.3	7.2	61.7
Өвчтэй байсан	0.1	0.3	1.4	0.1	2.0	1.0	1.1	0.7	6.7
Хөдөлмөрийн нас хүрээгүй	-	-	0.2	-	-	-	-	-	0.2
Өвчтөн, өндөр настан асарсан	0.1	1.0	1.5	0.1	1.2	0.7	0.6	0.5	5.7
Бусад	1.1	3.7	1.9	0.1	6.8	2.1	2.9	2.8	21.4

Хүснэгт 13. Эдийн засгийн идэвхгүй хүн амын тоо, насны бүлэг, дүүргээр, 2015 он

Насны бүлэг	Багануур, Багахангай	Баянгол	Баянзүрх	Налайх	Сонгинохайрхан	Сүхбаатар	Хан-Уул	Чингэлтэй	Нийслэлийн дүн
Эдийн засгийн идэвхгүй хүн ам, бүгд /мян.хүн/	12.7	61.3	97.1	9.3	100.7	44.3	45.9	52.4	423.7
15 - 19	2.9	14.5	21.4	2.5	23.7	7.6	10.3	8.9	91.8
20 - 24	1.8	9.3	13.0	1.3	14.8	5.8	5.5	7.5	59.0
25 - 29	1.1	5.0	10.0	0.5	8.3	4.1	3.5	4.4	36.9
30 - 34	0.8	3.5	6.5	0.5	6.5	2.3	2.7	3.4	26.2
35 - 39	1.1	3.5	5.6	0.1	5.7	2.3	2.2	3.2	23.7
40 - 44	0.7	3.2	3.1	0.3	4.9	2.0	1.5	2.8	18.5
45 - 49	0.6	2.4	3.6	0.2	4.1	1.5	2.1	2.4	16.9
50 - 54	0.8	3.1	5.4	0.7	7.1	2.6	2.9	2.5	25.1
55 - 59	1.1	4.5	9.2	1.0	7.9	5.3	4.1	4.6	37.7
60 - 64	0.8	4.2	6.9	0.8	6.3	3.3	4.0	4.2	30.5
65 - 69	0.4	4.2	5.5	0.4	3.0	2.4	2.9	3.6	22.4
70 +	0.6	3.9	6.9	1.0	8.4	5.1	4.2	4.9	35.0

Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөрийн хэлтэст бүртгүүлсэн бүртгэлтэй ажилгүй иргэдийн 38.6 хувь буюу 12,640 нь Улаанбаатар хотод амьдарч байна.

Хүснэгт 14. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо, насны бүлгээр, бүгд

Насны бүлэг	2009 он	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он
16-24	1,921	2,095	6,306	3,354	5,631	4,325	2,456
25-34	2,497	2,962	10,011	4,543	4,059	6,012	4,965
35-44	1,743	2,111	7,460	2,809	2,294	2,889	2,873
45-59	1,516	1,920	5,554	2,105	2,159	2,561	2,346
Ажилгүй иргэд /нийслэл/	7,677	9,088	29,331	12,811	14,143	15,787	12,640
Ажилгүй иргэд /улсын дүн/	38,077	38,250	57,171	35,776	42,772	36,970	32,788
Улсын дүнд эзлэх хувь	20.2	23.8	51.3	35.8	33.1	42.7	38.6

Хүснэгт 15. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо, насны бүлгээр, эмэгтэй

Насны бүлэг	2009 он	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он
16-24	954	906	2,875	1,836	3,201	2,571	1,297
25-34	1,375	1,487	3,911	2,540	2,276	3,509	2,872
35-44	986	1,124	3,232	1,498	1,280	1,518	1,629
45-59	797	971	2,766	1,006	1,059	1,174	1,121
Ажилгүй иргэд /нийслэл/	4,112	4,488	12,784	6,880	7,816	8,772	6,919
Ажилгүй иргэд /улсын дүн/	21,064	20,116	26,043	18,766	23,470	20,459	17,720
Улсын дүнд эзлэх хувь	19.5	22.3	49.1	36.7	33.3	42.9	39.0

Хүснэгт 16. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо, боловсролын төвшнөөр

Боловсролын төвшин	2009 он	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он
Бүртгэлтэй ажилгүй иргэд, бүгд	7,677	9,088	29,331	12,811	14,143	15,787	12,640
Дээд боловсролтой	1,721	2,060	6,955	5,041	5,800	6,422	4,595
Тусгай дунд боловсролтой	426	502	2,486	950	1,423	1,071	822
Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв төгссөн	299	387	1,989	918	750	851	611
Мэргэжилгүй	5,231	6,139	17,901	5,902	6,170	7,443	6,612

Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 21.4 хувь буюу 2,702 нь Чингэлтэй, 16.4 хувь буюу 2,068 нь Баянзүрх, 14.6 хувь буюу 1,844 нь Сүхбаатар, 14.3 хувь буюу 1,807 нь Баянгол, 12.9 хувь буюу 1,629 нь Сонгинохайрхан, 9.8 хувь буюу 1,247 нь Хан-Уул, 5.1 хувь буюу 642 нь Налайх, 4.6 хувь буюу 589 нь Багануур, 0.9 хувь буюу 112 нь Багахангай дүүрэгт тус тус амьдарч байна.

Хүснэгт 17. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо, дүүргээр, 2009-2015 он

Дүүрэг	2009 он	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он
Бүртгэлтэй ажилгүй иргэд, бүгд	7,677	9,088	29,331	12,811	14,143	15,787	12,640
Багануур	800	754	1,616	357	311	418	589
Багахангай	437	434	265	173	77	126	112
Баянгол	564	868	3,689	1,854	2,426	2,489	1,807
Баянзүрх	1,319	1,164	5,742	1,446	2,670	3,290	2,068
Налайх	102	219	1,515	1,395	1,266	1,093	642
Сонгинохайрхан	1,968	2,289	6,951	2,227	2,619	2,197	1,629
Сүхбаатар	744	543	2,461	2,729	1,635	1,925	1,844
Хан-Уул	850	600	1,745	919	1,027	1,964	1,247
Чингэлтэй	893	2,217	5,347	1,711	2,112	2,285	2,702